

# ЭРХЭЭ МЭДДЭГ БАЙГААРЫ: ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГАТАЙ ХАРИЛЦАХАД ЗОРИУЛСАН ЗААВАРЧИЛГАА



## ХЭРЭВ ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГЫН ЗҮГЭЭС НЭГЖЛЭГ ХИЙВЭЛ:

- Нэгжлэг хийхэд зөвшөөрөх шаардлагагүй. Хэрэв та нэгжлэг хийлгэхийг зөвшөөрөхгүй бол офицер хандан эелдэг байдлаар "Би нэгжлэг хийлгэхийг зөвшөөрөхгүй" гэж хэлээрэй.
- Хууль сахиулах байгууллага эрэн сурвалжлах үндэслэл бүхий сэжигтэй тохиолдолд нэгжих ажиллагааг үргэлжлүүлэх шийдвэр гаргаж болох ч зөвшөөрөл өгөхөөс татгалзсанаар та баривчлагдаж, гэмт хэрэгт буруутгагдаж байгаа тохиолдолд эрхээ хамгаална.
- Хууль сахиулах байгууллага ямар ч зөвшөөрөлгүйгээр таны утсыг нэгжиж болохгүй.

Алба хаагч гэмт хэргийг шалгахын тулд таны эд зүйлсийг шалгаж үзэхийг нэгжлэг гэнэ. Офицерт өөрийн эд зүйл, тэр дундаа утсаа сайн дураараа өгөх нь нэгжлэг хийхийг зөвшөөрсөнд тооцогдоно



**Бод.**  
**Амьсгал.**  
**Эрхээ мэддэг бай.**

"Би оюутнууд, ажилчид, гэр бүлийнхэндээ сургуулийн амар амгалан, аюулгүй байдалд голчлон анхаарлаа хандуулдаг гэдгийг батлахыг хүсэж байна. Оюутнууд хууль сахиулах байгууллагатай харилцахдаа өөрсдийн эрхээ мэдэж, хуулийн дагуу хамгаалагдсан байдгаа ойлгох нь оюутны аюулгүй байдлыг хэзээд хангаж байх олон арга замын нэг юм."  
-Доктор. Франсиско Дюран, Захирал

## ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГАТАЙ ХАРИЛЦАХДАА:

- **Тайван бай.** Та явж болох эсэхээ тайван асууж болно; хэрэв зөвшөөрвөл та чимээгүйхэн, тайван алхаад явж болно.
- **Та дуугүй байх эрхтэй.** Офицер хандан "Би дуугүй байх эрхээ эдлэхийг шаардаж байна, тантай ярилцахыг зөвшөөрөхгүй" гэж хэлээрэй. Хэрэв танаас мэдэгдэл бичих эсвэл гарын үсэг зурахыг хүсэх юм бол "Би мэдэгдэл хийхийг хүсэхгүй байна" эсвэл "Би дуугүй байхыг хүсэж байна" гэх зэргээр татгалзаж болно.
- **Та эцэг эх, асран хамгаалагчтайгаа** ярихын тулд "Би эцэг эх/асран хамгаалагчтайгаа яримаар байна" гэж асууж болно. Гэсэн хэдий ч хууль сахиулах байгууллага эцэг эх/асран хамгаалагчийн оролцоогүйгээр эсвэл эцэг эх/асран хамгаалагчид тохиолдлын талаар мэдэгдэхээс өмнө тантай ярилцаж болно. Та дуугүй байх эрхтэй хэвээр байна. Та офицеруудад дуугүй байх, тэдэнтэй ярихгүй байх эрхээ эдэлж байгаагаа хэлж болно.
- **Та өмгөөлөгч хүсэх** хийгээд дуугүй байх эрхтэй.

## ТА ДАРААХЫГ АНХААРНА УУ:

- Маргалдах, эсэргүүцэх эсвэл зугатаж болохгүй.
- Танд эвгүй байгаа, буруу санагдах эсвэл ойлгохгүй байгаа мэдэгдэл хийх эсвэл гарын үсэг зурж болохгүй.
- Офицерыг эсэргүүцэх эсвэл аюул учруулахыг оролдож болохгүй.

